САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗААВАР

## ФИН-А СИСТЕМ

2025.08.25

# Фин-А системийн тухай

- **FINA IRP** (Integrated Regulatory Platform) нь Төв банкууд болон хяналтын байгууллагуудад зориулсан дэвшилтэт **SupTech** шийдэл.

- Санхүүгийн байгууллагуудаас тайлан, мэдээлэл хүлээн авах, удирдах, нэгтгэх үйл ажиллагааг хялбаршуулах цогц систем.

- Гүрж Улсын “Фина” ХХК нь тус системийг 2006 оноос хойш Дэлхийн 14 улс орны 12 төв банк, 15 агентлагт амжилттай нэвтрүүлсэн.

- Манай улсад Санхүүгийн зохицуулах хороо 2011 оноос хойш, Монголбанк 2013 оноос хойш ашиглаж байна.




- Java дээр хөгжүүлэгдсэн энэхүү систем нь вебэд суурилсан тул аль ч үйлдлийн систем (Windows, Linux, AIX, MacOS, Android, iOS) дээр ажилладаг.

- HTTPS, имэйл робот, оффлайн илгээх хэрэгсэл, онлайн өгөгдөл оруулах модуль зэрэг олон сувгаар дамжуулан тайлан хүлээн авах боломжтой.

- XBRL, XML, XLSX, CSV зэрэг олон төрлийн өгөгдлийн форматыг боловсруулдаг.

- Тайлан хүлээн авах метадата болон нэгтгэлийн загвар үүсгэх, боловсруулахад хялбар.

- Business Intelligence Tool-уудтэй уялдан дашбоард хөгжүүлэх боломжтой.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Фин-А системийн шинэчлэл, шинэ давуу талууд




- RegTech (RegulatoryTechnology) хүрээнд OST validator программыг ашиглан алдаатай, дутуу тайлан илгээх эрсдэлээс зайлсхийж, системийн ачааллыг бууруулсан.
- SupTech (Supervisory Technology) ашигласнаар санхүүгийн байгууллагуудаас ирүүлсэн тайланд автоматаар боловсруулалт хийж зөрчил, эрсдэлийг эрт үнэлэх, үнэн зөв мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой болсон.
- Хэрэглэгчийн мэдээлэл, нууц үгийн тохиргоог хэрэглэгч өөрийн эрхээр тохируулах боломжтой болсон.
- Технологийн хувьд бие даасан үйлдлийн систем, датабаазтай тул нэгтгэл, мэдээ боловсруулах хурд сайжирсан.
- Зохицуулалттай байгууллагуудаас ерөнхий асуумж авах модулыг шинээр нэвтрүүлсэн.
- Системийн харагдах байдал шинэчлэгдэж илүү ойлгомжтой, хялбар болсон.

# Тайлан, мэдээ ирүүлэх мастер файлыг татан авах

Хорооны цахим хуудас






# Тайлан, мэдээ илгээхдээ анхаарах асуудлууд




- ! Тайлан, мэдээг илгээхдээ мастер файлыг тухай бүр **Хорооны цахим хуудсаас шинээр татах**
- ! Мастер файл бүрийн **Зааварчилгаа хуудастай уншиж, танилцах**
- ! Файлын төрөл нь **Excel workbook (*.xlsx)** байх ёстойг анхаарах
- ! Тайлангийн нэгжийн оронг анхаарах
- ! Хүснэгтийн нүдэнд аливаа бодолт хийж болохгүй, зөвхөн гараас анхны утга оруулахыг анхаарах

# Системд нэвтрэх

**WWW.FRC.MN**

**ЦАХИМ ТАЙЛАН**

**ВЕБЭЭР ИЛГЭЭХ**




**Хэрэглэгчийн нэр**: Хуулийн этгээдийн регистрийн дугаар

**Нууц үг:** Системд нэвтрэх нууц үг

# Нууц үг сэргээх




Хэрэв нууц үг солих бол нууц үг сэргээх хэсгээр нэвтэрч системд бүртгэлтэй цахим шуудангийн хаягийг оруулж хүсэлт илгээнэ.







Цахим шууданд ирсэн нэг удаагийн нууц үгийг системд оруулснаар шинээр нууц үг солих хэсэг гарч ирнэ.

Нууц үгийг 5 удаа буруу хийвэл БЛОК хийгдэх бөгөөд энэ тохиолдолд СЗХ-ны МТХ-ийн хэлтэст хандана уу.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Системийн үндсэн цэс




Баруун дээд буланд байрлах системийн тохиргооны хэсэгт хэрэглэгчийн бүртгэл, дэлгэцийн тохиргоо болон нууц үг солих цэсүүд байрлана.

# Системийн үндсэн тохиргоо цэс







2




**Хэрэглэгчийн профайл хэсэгт мэдээллээ бүртгүүлснээр нууц үгийг цахим шуудан ашиглан сэргээх, Хорооноос санхүүгийн тайлантай холбоотой илгээж буй мэдээллийг хүлээн авах боломж бүрдэнэ.**

Системийн тохиргоо цэсний OST баталгаажуулагчийг татан ашигласнаар санхүүгийн тайланг системд илгээхээс өмнө онлайн, оффлайн орчин харгалзахгүйгээр алдаа байгаа эсэхийг шалгах боломжтой.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Системд тайлан илгээх




| NBFIXXXXXXq0QYYYY.xls | |
|---|---|
| **NBFI** | Банк бус санхүүгийн байгууллагыг илтгэж буй товч нэр (үг 3 үсгийг жижгээр эсвэл томоор бичнэ) [Тогтмол] |
| **XXXXXX** | тухайн байгууллагын регистрийн дугаар |
| **q** | тайлангийн төрөл [Тогтмол], q – улирал |
| **0Q** | улирлын дугаар [эдгээрийн тохирохыг бичнэ: **01, 02, 03, 04**] |
| **YYYY** | тайлант он [**Тоо**] |

Улирлын болон сарын мэдээг системд ачаалахдаа зөв нэрлэсэн эсэхийг сайтар шалгана уу.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Илгээсэн тайланд алдаа гарвал тухайн алдааг харах



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Гараас оруулах буюу Аудитын өөрчлөлтийг тайланд оруулах




Өөрчлөлт орсон тайлангийн утгуудыг гараас завсарлаж, хадгалах үйлдлийг хийнэ. Амжилттай хадгалагдвал тайлангийн төлөв засварласан төлөвт шилжинэ. Өөрчлөлтүүдийг оруулж дууссаны дараа илгээх товчийг дарснаар Санхүүгийн зохицуулах хороонд илгээгдэнэ.

**Санхүүгийн тайланд өөрчлөлт оруулах бол хариуцсан салбарын хянан шалгагчид мэдэгдэх шаардлагатай!**

# OST Баталгаажуулалтын программын давуу тал

## 1. Тайлангийн илгээх хялбар, шуурхай процесс

Тайланг үнэн зөв, алдаагүй илгээхэд хялбар болгож харьцуулалтын дүрмийг нарийвчлах боломж

## 2. Дотоод баталгаажуулалт ба харьцуулалт

Тайлангийн файлыг системд илгээхээс өмнө оффлайн орчинд дотооддоо шалгаж, шаардлага хангаж буй эсэхийг нягтлах боломж




## 3. Кросс-платформ дэмжлэг

Windows, MacOS, болон Linux үйлдлийн системүүд дээр ажиллах боломжтой бөгөөд Интернэтийн хэрэглээг 80%, процессорын ачааллыг 70% бууруулах боломж

## 4. Мэдээллийн аюулгүй байдал

Зохицуулалтын байгууллага бүрд зориулсан сертификат файлыг таниулснаар мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах боломж

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# OST Баталгаажуулалтын программыг суулгах




**1** СЗХ-оос тайлан илгээх эрхтэй санхүүгийн байгууллага бүрт OST validator программыг ашиглах сертификатыг идэвхжүүлэн цахим шуудангаар хүргүүлнэ.

**2** Хэрвээ компьютерт тань Java платформыг суулгаагүй бол та интернетээс сүүлийн хувилбарыг үнэгүй татан авч суулгах боломжтой.

https://www.java.com/en/download/

**3** OST Validator программыг тайлан илгээх веб сайт (https://dcs.frc.mn)-д өөрийн эрхээр нэвтрэн татан авч суулгана.

# OST Баталгаажуулалтын программд нэвтрэх




**Certificate** гэсэн хэсэгт СЗХ-оос илгээсэн сертификат файлыг оруулна.

**Identify** гэсэн хэсэгт байгууллагын РД эсхүл бүртгэлийн дугаарыг оруулна.

**Password** гэсэн хэсэгт нэг удаагийн нууц үгийг **оруулснаар** Check товчийг дарна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# OST Баталгаажуулалтын программыг ашиглах




Хэрэв check хийхэд амжилттай болвол Next товчийг дарна.




Санхүүгийн тайлангаа add хийн хяналтын самбарт байршуулан Validate & Process товчийг дарж алдааг шалгана.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# OST Баталгаажуулалтын программыг ашиглах



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# OST Баталгаажуулалтын программыг ашиглах




1. Хэрэв шалгасан тайланд алдаа гараагүй бол нэвтрэх нэр, нууц үг хийх хэсэг гарч ирэх бөгөөд DCS системийн эрхээ оруулж Upload товчийг дарснаар илгээх боломжтой.

2. Мөн save as хэсгийг сонгосноор **excel** болон **fina** өргөтгөлтэйгөөр алдаагүй санхүүгийн тайлангаа хадгалах боломжтой.

Тайлан хүлээн авах хугацаанд “Upload” товчийг дарснаар файл DCS системд хуулагдаж, СЗХ-нд ирэхийг анхаарна уу.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Мастер файл илгээхэд түгээмэл гардаг алдааны тайлбар

## Файлын нэр буруу

- MS EXCEL (.xslx) өргөтгөлтэй хадгалаагүй
- Мастер файлын нэршлийг форматын дагуу өгөөгүй

## СБ буруу

- Файлын нэршилд регистрийн дугаарыг буруу оруулсан
- Өөр байгууллагын эрхээр системд нэвтэрсэн

## Татгалзсан

- Тайлан хүлээн авах хугацаа дууссан эсхүл файлын хугацааг буруу нэрлэсэн
- Хянан шалгагч зөвшөөрөх үйлдэл хийсний дараа тайлан мэдээг дахин илгээсэн

## Гарын үсэг буруу

- Мастер файлыг MS-Excel дээр бус бусад программаар нээж хуудасны хамгаалалтыг эвдсэн
- Хорооны цахим хуудаст байршуулсан мастерфайлыг ашиглаагүй

## Матрицын алдаа

- Буруу мастер файлаар илгээсэн (мастер файл шинэчлэгдсэн үед хуучин файлыг илгээх үед)
- Мастер файлын нэршлийг өөр тайлангийн нэршлээр нэрлэсэн

## Unexpected error. Админтай холбогдоно уу

- Мастерфайлын нүдэнд оруулсан утгын урт хэтэрсэн
- Хянан шалгагч зөвшөөрөх үйлдэл хийсний дараа тайлан мэдээг дахин илгээсэн

# Анхаарал хандуулсанд баярлалаа

